

“МОНГОЛЧУУДЫН УГ ЭХ, ГЭРИЙН ТҮҮХ” СЭДЭВТ АРХИВЫН БАРИМТЫН ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Монголчуудын дунд бичиг үсэг үүсэн бий болсон тэр цаг үеэс ургийн буюу овгийн бичиг, гэрийн түүхийг үйлдэн хөтлөх уламжлал дэлгэрчээ.

Угийн бичиг буюу гэрийн үеийн бичмэл үйлдэх ёс нь XIII зуунаас ХҮII зууны сүүл үе хүртэл тогтвортой уламжлагдаж байсан ба Манж Дайчин улсын ноёрхолын үед нэлээд суларсан боловч өнөөдрийг хүртэл уламжлал тасраагүй байна. Ийнхүү удам судраа хөтлөх нь монголчуудын хүн ам зүйн нэг хэсэг байсан төдийгүй төрийн албаны залгамж холбоог илэрхийлэх, өөрийнхөө удам угсааг мэдэх ураг төрлөө таньж хүндэтгэх, өргөж тэтгэх ёсыг баримтлах, үр удмаа үлдээх зэрэг аж төрөх ухаан төдийгүй өвлөх өвлүүлэх, хэргэм зэрэг залгах, нийгэм хууль зүйн учир холбогдолтой байсан.

Монгол Улсын Засгийн газрын "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Архивын ерөнхий газар, Үндэсний төв архиваас Соёлын яам, Чингис хаан үндэсний музейтэй хамтран "Монголчуудын уг эх, гэрийн түүх" сэдэвт архивын баримтын үзэсгэлэнг зохион байгуулж нь монголчуудын угийн бичиг, түүнд холбогдох бичгийн өвийг түгээн дэлгэрүүлэх, судлан сурталчлах танин мэдэхүйн ач холбогдолтой болно.

"Монголчуудын уг эх, гэрийн түүх" сэдэвт архивын баримтын үзэсгэлэнд Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдан буй ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэлийн дотроос онцлон дурдвал "Түшээт хан аймгийн Түшээт ханы хошууны тайж Бат-Очир, Арсай баян нарын гэрийн үеийн бичмэл" /1740 он/, "Сэцэн хан аймгийн Сэцэн ханы хошууны хошууны засаг тайж нарын гэрийн үеийн бичмэл" /1745/, "Засагт хан аймгийн ноёдын түүх", УТА-ын сан хөмрөг дэх манж хэлээр бичигдсэн "Гэрсэнз Жалайр хунтайжийн гуравдугаар хөвгүүн Ноонохын үр ач нарын гэрийн үеийн бичмэл", "Торгуудын Аюук хааны үр хойчийн гэрийн үеийн бичмэл" /1873/ зэрэг урьд өмнө олон нийтэд танилцуулагдаж байгаагүй олон уг эх, гэрийн түүхийг илтгэх хосгүй үнэтэй архивын 40 гаруй баримтыг дээжлэн тавьсан болно.

Монголын үрс маш олон болтугай.

Үзэсгэлэнгийн нээлт:

Чингис хаан үндэсний музейн тавдугаар давхар

"Мөнгөн мод" үзэсгэлэнгийн танхимд

2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 13:30-д болно.

Та бүхэн манай үзэсгэлэнг таалан болгооно уу.

ӨМНӨТГӨЛ

Монголчууд өөрсдийн өвөг дээдэс, удам угсаагаа нэвтэрхий сайн мэддэг гэдгээрээ дорно дахины улс түмэнд гайхагдсан бахдам түүхтэй ард түмэн билээ.

XIV зууны персийн алдарт эрдэмтэн, түүхч Рашид Ад Дин “Судрын чуулган” хэмээх бүтээлдээ *“Эдгээр /Монголын/ бүх аймаг яруу тодорхой удам угсааны модтой /түүхтэй/. Учир нь монголчуудын заншил нь өвөг дээдсийнхээ удам угсааг залган сахиж, төрсөн хүүхэд бүрдээ удам угсаагаа зааж сургадаг. Тийнхүү тэд удам угсааны тухай үгийг хүмүүсийн хүртээл болгодог учраас тэдний дунд яс угсаа, овог аймгаа мэдэхгүй хүн нэг ч байдаггүй”* хэмээн магтан тэмдэглэжээ. Монголчуудын дунд өөрсдийн удмынхны түүхийг уг удмын өндөр дээд өвгөөсөө эхлэн аман болон бичгийн хэлбэрээр тэмдэглэн үлдээх уламжлал нэн эрт үүсч, тэр нь тухайн нийгмийнхээ хөгжлийн төвшинтэй холбогдон эхэндээ овгийн нийтийн түүх шинжтэй байснаа, аажимдаа феодалын харилцаа бэхжихийн хирээр өрх гэрийн түүх болон хувирсан байна.

Монгол Улсын Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдан буй эрдэмтэн судлаачид төдийлөн түгээмэл ашигладаггүй цөөн тооны цуглуулга хөмрөг байдгийн нэг нь “Ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэл” хэмээх цуглуулга хөмрөг болно.

Манж Чин болон Богд хаант Монгол Улсын үеийн ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэлийн хөмрөгт нийт 2089 хадгаламжийн нэгж буюу мөн тэр тоон адил адил гэрийн үеийн бичмэл хадгалагдаж байна. Тэдгээр хадгаламжийн нэгжийн доторх гэрийн үеийн бичмэлийг үйлдэхдээ түүхчлэн бичих, хүснэгтлэн зурж үйлдэх хоёр аргын аль алиныг нь хэрэглэжээ. Гэрийн түүхийг “уг эх”, “гэрийн түүх”, “гэрийн үеийн бичмэл”, “гэрийн зураг”, “үе үеийн явдлын илтгэл” гэх мэт олон янзаар нэрлэж байсан боловч дээр өгүүлсэн түүхчлэн бичсэнийг “уг эх”, хүснэгтлэн зурж үйлдсэнийг “гэрийн үеийн бичмэл” гэж их төлөв нэрлэж байжээ. Харин бидний үед гэрийн түүх, түүний дотор хүснэгтлэн зурж үйлдсэнийг “угийн бичиг” хэмээн нэрлэж, бичих явдал

түгээмэл болсноор уг нэр гэрийн түүхийг бүхэлд нь нэрлэн нэр томъёо болон хэлбэршин тогтсон байна.

“Ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэл” цуглуулга хөмрөгийн баримт бичгүүдийг аймаг, хошуугаар ялгахаас гадна мөн хошуу дотроо:

1. Төрлийн тайж нарын гэрийн үеийн бичмэл
2. Харъяат тайж нарын гэрийн үеийн бичмэл
3. Насанд хүрч зэрэг гуйх тайж нарын гэрийн үеийн бичмэл гэж ангилж үзэж болохоор байна. Тэмүжин-Чингис хааны шууд удмын тайж нарыг төрлийн тайж, дүү нарынх нь удмын тайж нарыг харьяат тайж хэмээн нэрлэдэг.

Гэрийн үеийн бичмэлийг цаас, даавуун дээр амьд байсныг нь улаан бэхээр, бие барсныг нь хар бэхээр тэмдэглэж, дөрвөлжин, урт нарийн/ өргөн нь 10см-1м, урт нь 1м-3м /дүгрэг/ гэрийн дээвэр мэт /диаметр нь 1-5м хүртэл/ гэх мэт олон янзын хэмжээ, хэлбэртэйгээр үйлдэж, ноёдын уг эхийг ихэвчлэн данс хэлбэрээр бичиж үлдээжээ.

Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгадагдан буй ноёд тайж, лам нарын уг эх, гэрийн түүхийн үндсэн агуулга нь засаг ноёдын уг эх, зэрэг задгамжилсан гэрийн түүх, насанд хүрч зэрэг олгох хөвгүүд, хэргийн учир өөр аймаг хошуунд цөлөгдөж захирагдсан тайж нар, хөвгүүнгүй учир “балардсан” тайж нарын зэргийг сэргээн залгамжлагчдын гэрийн түүх, зарим томоохон хутагт нарын товч түүх, хошуудын газар нутгийг тодорхойлсонд түүхэн эх сурвалжийн үнэ цэнэ нь оршино.

ҮЗЭСГЭЛЭНД ДЭЛГЭГДСЭН БАРИМТЫН ЖАГСААЛТ

Сэцэн хан аймгийн сайд жанжин, жүн вангийн зэрэг Бишрэлт засаг, хошууны бэйс Доржцэрэнгийн хошууны тайж нарын насанд хүрч зэрэг олгуулахыг гуйх хөвгүүдийн уг эх салбарын зураг. 1915 он

МУУТА, ТБА, ХА-233, Д-1, ХН-127, Б.1

Сэцэн хан аймгийн дөтгөөр зэргийн тайж Лхаваан, Дүгэржав нарын гэрийн үеийн бичиг. 1915 он

МУУТА, ТБА, ХА-233, Д-1, ХН-127, Б.2

Түшээт хан аймагт хавсаргаг захиргасан Цахар хошууг захирах Ялгуунбаатар дөрвөн зэрэг тэмдэглэсэн, хар нүдний тогосын отго, бэйсийн зэрэг засаг улсын түшээ гүн Сумьяагийн хошуунаас олгож мэдүүлсэн гэрийн үеийн бичмэл. 1918 он

МУУТА, ТБА, ХА-233, Д-1, ХН-8, Б.2

Түшээт хан аймагт хавсаргаг захиргасан Цахар хошууг захирах Ялгуунбаатар дөрвөн зэрэг тэмдэглэсэн, хар нүдний тогосын отго, бэйсийн зэрэг засаг улсын түшээ гүн Сумьяагийн уг эхийг тодорхойлсон цэс. 1919 он

МУУТА, ТБА, ХА-233, Д-1, ХН-65, Б.1

Засагт хан аймгийн Хойдын засаг тэргүүн зэрэг тайж Сэдэвцэдэнсүрэнжавын уг эх, гэрийн үеийн бичмэл. 1913 он

МУУТА, ТБА, ХА-233, Д-1, ХН-8, Б.2

Засаг бэйсийн зэрэг Алтан-Очир миний уг эх, гэрийн үеийн бичмэл. 1914 он

МУУТА, ТБА, ХА-233, Д-1, ХН-172

Засагт хан аймгийн ноёдын түүх /он тодорхойгүй/.

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-827

Халхын Хан уулын чуулганы Ноён хутагт Жамьян-Ойдовжамцын уг эх, хувилсан үе, овог нэр, цол зүйлийг байцаасан дэвтэр данс. 1793 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-5

Түшээт хан аймгийн Түшээт ханы хошууны торгууд тайж нарын гэрийн түүх. 1825 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-9

Халхын Сэцэн хан, махасамати гэгээн Шолойгоос эхлэн 14 үеийн үр ач нарын шинэчлэн зохиосон гэрийн үеийн бичмэл. 1825 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-9

Түшээт хан аймгийн Цогтой гүн, Эрдэнэ гүн, Дайчин бэйсийн хошууны зэрэг залгамжлах тайж нарын гэрийн үеийн бичмэл. /он тодорхойгүй/.

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-594

Халхын Сэцэн хан, махасамати гэгээн Шолойн угийн бичиг /XIX зууны сүүл үе/.

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-604

Чингис даян хааны таван дүү нарын уг эх / он тодорхойгүй/.
МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-678, Б.2

Батмөнх даян хааны арван нэгдүгээр хөвгүүн Гэрсэнз Жалайр хунтайжийн уг эх. / он тодорхойгүй/.
МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-683

Түшээт хан аймгийн харьяат тайж Даарийжав, Гонгор нарын гэрийн үеийн бичмэл. 1875 он
МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-701

Түшээт хан аймгийн тайж Чимэддорж нарын гэрийн үеийн бичмэл. 1825 он
МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-734

Сэцэн хан аймгийн Сэцэн ханы хошууны олон ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэл.
/ он тодорхойгүй/.
МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-8

Олон удаагийн засвар хийж засвар тус бүрт ханы тамга дарсан Сэцэн хан аймгийн олон ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэл. 1885 он
МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-25

Халхын Сэцэн хан аймгийн Сэцэн ханы хошуунаас туртайяа лам болохыг хүсэгчдээс гэрээс гарах тэмдэгт бичиг олшохыг хүссэн цэс. 1902 он
МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-42

Халхын Сэцэн хан аймгийн засаг хошой чин ван Базарсид миний уг эх, овог төрөл зүтгэсэн газрыг байцаасан дэвтэр. 1779 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-58

Халхын Сэцэн хан, махасамати гэгээн Сэцэн ханаас нааш засаг Буяндэлгэр миний уг эх, олон тайж нарын гэрийн үеийн бичмэл. 1845 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-64

Халхын Сэцэн хан аймгийн цянь чин мэнд явах хуувийн сайд, ардан дөрвөн зэрэг нэмсэн, есөн зэрэг тэмдэглэсэн засаг хошой чин ван На-гийн хошууны бие барсан тайж Мөнхтөрийн уг дөтгөөр зэргийн тайжийг залгамжлах Сэдэдийн уг эх салбар гэрийн үеийн бичмэл. 1899 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-82

Сэцэн хан аймгийн жонон Цэвдэнгийн уг эх /он тодорхойгүй/.

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-91

Сэцэн хан аймгийн Да гүнтний хошууны ноёд, тайж нарын гэрийн үеийн түүх. 1804 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-92

Сэцэн хан аймгийн тайж Мүнжингийн гэрийн үеийн бичмэл. 1805 он.

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-124

Халхын Сэцэн хан аймгийн засаг тэргүүн зэргийн тайж Равдандоржоос дараалан тус хошууны бүхий олон тайж нарын уг эх. 1825 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-697

Түшээт хан аймгаас ял халдаж Сэцэн хан аймагт захирагдсан Батмөнх даян хааны үрс төрлийн тайж ястай Мөнхжаргалын төрсөн хөвгүүдийн уг эх. 1855 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-752

Халхын Сайн ноён аймгийн дэд зэрэг тайж Сандуйн багийн тайж нарын гэрийн үеийн бичмэл түүх. 1845 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-884

Халхын Түшээт хан аймгийн буй бүхий ван, бэйс, гүн, засаг нарын хэргэм зэрэг залгамжилсан түшмэлийн зэрэг нэмсэн, отго, жолоо шагнагдсан ноёдын нэрс. 1903 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-79

Түшээт хан аймгийн төрлийн дарга, харьяат тайж Гомбын Бадаргуулт төрийн арван нэгдүгээр онд үйлдсэн гэрийн үеийн бичмэл түүх. 1885 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-215

Торгуудын Аюук хаанаас салсан үр ач нарын гэрийн үеийн бичмэл. 1875 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-273, Б.48

Чингис хааны дүү бөх Бэлгүтэйн үр удмыг тэмдэглэсэн гурийн үеийн бичмэл. 1817 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-726, Б.1-4

Төр гэрэлтийн арван есдүгээр оны хоёрдугаар сарын 20-нд Түшээт хан аймгийн тайж Манжила нарын уг эхийг тодорхойлон бичсэн гэрийн үеийн бичмэл. 1840 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-740

Хорчин тайж Чимэд нарын гэрийн үеийн түүх.

/он тодорхойгүй/

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-800, Б.1-3

Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдан буй манж бичгээр бичигдсэн Гэрсэнз Жалайр хунтайжийн удмын 9 үеийн ноёд, тайж нарыг тэмдэглэсэн гэрийн үеийн бичмэл.

/он тодорхойгүй/

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-99, Б.1

Сайн ноён аймгийн Чин сүжигт Номун хан хутагтын уг эх, дүр тодруулсныг байцаасан данс. 1830 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-906, Б.1-16

Сайн ноён аймгийн Эрдэнэ бандидаа хутагтын уг эхийг байцаасан данс. 1850 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-7, ХН-907, Б.1-15

Түшээт хан аймгийн Түшээт ханы хошууны тайж Бат-Очир, Арсай баян нарын гэрийн үеийн бичмэл. 1740 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-1, Б.1-26

Сэцэн хан аймгийн Сэцэн ханы хошууны засаг тайж нарын гэрийн үеийн бичмэл. 1745 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-2, Б.1

Халхын Зүүн гарын цэргийг захирах туслагч жанжин засаг хошой чин ван Чавагдоржийн уг эх, залгамжлах үе удаа, цол, отгын зэргийг байцаасан данс. 1779 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-103, Б.1-6

Халхын Сайн ноёд засаг хошой чин ван, Сайн ноён цол залгамжлуулсан Манж Дайчин улсын хааны зарлиг. 1781 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-2, ХН-815, Б.1-6

Хан уулын чуулганы дэд дарга засаг улсын түшээ гүн Г.Чагдаржавын уг эхийг байцаасан данс. 1905 он

МУУТА, ТБА, ХМ-168, Д-1, ХН-241, Б.1-30

